

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Эмэгтэйчүүдийн боловсрол, эдийн засаг, боломжийн төлөөх залбирал

Эмэгтэйчүүдийн хамгийн том, давтагддаг сорилт бол боловсролд хүрэх боломж юм. UNESCO-гийн 2024 оны тайланд дурдсанаар, дэлхий даяарх 700 сая бичиг үсэг тайлагдаагүй насанд хүрэгчдийн гуравны хоёр нь эмэгтэйчүүд байна. Бичиг үсэгт тайлагдана гэдэг нь зөвхөн бусадтай харилцах тухай биш харин мэдээллийн асар их урсгал дундаас чухал баримтыг шүүн тунгааж, дүгнэх чадвартай шууд холбоотой. “ЭЗЭНээс эмээх нь мэргэн ухааны эхлэл бөгөөд Ариун Нэгэнийг таних нь ойлголт мөн” (Сургаалт үгс 9:10). Зүгээр уншиж сурахаас гадна, эмэгтэйчүүд Библийг өөрсдөө уншиж ойлгодог болж, Бурханы өгдөг мэргэн ухаанаар дамжин Түүний хайрын утга учрыг гүн гүнзгий мэдэрч, ямар ч бэрхшээлд ганхахгүй байхын төлөө залбирья.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면 매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

1. Арабын ертөнцийн эмэгтэйчүүдийг хайр, үнэн, амар тайвны эх сурвалж болох Таныг эрэн хайхаар сэрээж өгөөч. Та тэдний цөхрөлийг найдвар болгон, айдсыг итгэл болгон хувиргаач. (Иер. 29:13)

2. Эзэн минь, Беларусьт эцэг эхчүүд хүүхдүүдээ гэрээр сурган хүмүүжүүлэх боломж дахин нээгдэж, бурханлаг ертөнцийг үзэх үзлээр энэ шинэ үеийг төлөвшүүлэх болтугай. (Сур. 22:6)

3. Бурхан минь, Бонайрын эмэгтэйчүүд чанартай боловсрол, зохистой ажил, эдийн засгийн боломжид шударгаар хүрч, ядуурлын мөчлөгөө таслах болтугай. (Фил. 4:19)

4. Эзэн минь, Ботсванагийн шинэ засгийн газар сургуулиудын сахилга батыг бэхжүүлж, их сургуулиуд оюутнуудад ажил эрхлэхэд хэрэгтэй амьдралын ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэх болтугай. (Сур. 4:5)

5. Бурхан минь, Бразилийн удирдлагад хүнсний үнэ, татвар нэмэгдэж иргэдэд хүндрэл учруулж буй эдийн засгийн асуудлыг шийдэхэд мэргэн ухаан өгөөч. (Иса. 33:6)

6. Эзэн минь, Камбожид мөнгө, эрх мэдэлтэй хүмүүсийн зүгээс иргэдийн хууль ёсны өмчийг булаан авч буйд шударга ёс тогтоож өгөөч. (Иса. 61:8)

7. Эзэн минь, Хятадын боловсролын удирдагчдад AI болон хүн амын хөгшрөлтөөс үүдсэн сорилтуудыг зохицуулах мэргэн ухаан өгөөч. Хөдөө орон нутаг, цөөнх бүлгийн сурагчдад боловсрол хүртээмжтэй байх болтугай. (Сур. 4:13)

8. Данийн залуус сэтгэл зүй, сэтгэл хөдлөлийн бэрхшээлээс болж сургуульдаа дасан зохицож чадахгүй тэмцэж байна. Тэд болон гэр бүлүүдэд нь тусламж өгөөч. (Иса. 26:3)

9. Бурхан минь, Доминиканы БНУ-ын зарим эмэгтэйчүүд гэр бүлээ тэжээхийн тулд биеэ үнэлэлтэд орсон байна. Тэдэнд зөв замаар мөнгө олох өөр зам нээж өгөөч. (Мт. 6:31-33)

10. Эзэн минь, Эсватини улсын бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд ажлын байр нэмэгдэх, санхүүгийн нээлт, бүтээлч санаа өгөөч. Гараар нь хийдэг ажлыг ерөөж, ядуурлын мөчлөгийг таслахад нь туслаач. (Дэд хууль. 8:18)

11. Эцэг минь, Францын төрийн удирдагчдад дэг журам, үндсэн үйлчилгээ, иргэдийн эрхийг хамгаалах, нийгмийн нийтлэг сайн сайхныг дэмжих мэргэн ухаан өгөөч. (Ром. 12:21)

12. Эзэн минь, Индонезид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс ч бага цалин авдаг, ядууралд өртөмтгий ажилчдыг бэхжүүлж, шударга, сайхан амьжиргааны боломж нээж өгөөч. (Дуу. 9:18)

13. Бурхан минь, Японы сүмүүд өндөр настай эмэгтэйчүүд, ганц бие ээжүүдийг санхүү болон сүнслэг талаас нь халамжилж, ядуурлын өндөр эрсдэлээс хамгаалах болтугай. (Дэд хууль. 24:17-22)

14. Эзэн минь, Ливан, Йемен, Судан, Ливид асар их өрөнд орсон эмэгтэйчүүдэд хүнсний баталгаа, ядуурлаас гарах тусламж, хүүхэд асрах найдвартай байдал, санхүүгийн бие даах замуудыг нээж өгөөч. (2 Кор. 9:8)

15. Эзэн минь, Монголын хөдөө орон нутгийн хүүхдүүдэд хэрэгтэй нөөц, багш, чанартай боловсролын төлөө бид Таныг эрж байна. Ирээдүйнх нь төлөө Таны найдвараар тэднийг дүүргээч. (Сур. 18:15)

16. Эзэн минь, Хойд Кавказад өр ба өндөр хүүгийн дарамтад буй хүмүүс найдвар олж, Танаас мэргэн ухаан, хүч авч, боломжийнхоо хэмжээнд амьдрах болтугай. (Фил. 4:13)

17. Эзэн минь, Папуа Шинэ Гвинейн удирдагчдыг санхүүгийн тогтворгүй энэ үед чиглүүлээч. Нийгэмлэгүүд боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, найдвар, тогтвортой өсөлтийг хүртэх урт хугацааны үйлчилгээг байгуулах мэргэн ухаан хайрлаач. (1 Тим. 2:1-2)

18. Эзэн минь, Парагвайд эмзэг нөхцөлд буй эмэгтэйчүүдэд Өөрийн бүхэллэг (бүрэн эдгэрэл)-ээр үйлчилж, хэрэгцээг нь хангах ажил эрхлэх боломж олгуулж өгөөч. (Сур. 31:25-26)

19. Эзэн минь, Румыны хөдөө нутгийн эмзэг охид ядуурал, гэр бүлийн хүнд байдлаас болж сургуулиа орхих нь элбэг. Тэднийг хамгаалж, хүний наймаанд өртөхөөс сэргийлээч. (Дуу. 9:9)

20. Эзэн минь, Өмнөд Африкийн Зүүн Кейпийн хөдөө нутгийн хүүхдүүд адил тэгш боловсролын боломж хүртэх болтугай. Зарим нь сургуульдаа хүрэхийн тулд өдөр бүр урт зам алхдаг. (Дэд хууль. 6:7)

21. Эзэн минь, Өмнөд Солонгост жил бүр асрамжийн системээс гардаг 2,500 гаруй 18 настанд боловсрол, дэмжлэг өгч, бие даан амжилттай амьдрахад туслаач. (Дэд хууль. 10:18)

22. Эзэн минь, Сири, Йемен, Судан болон Хойд Африкийн хөдөө бүсийн удирдагчдын зүрхэнд хөдөлж, эмэгтэйчүүдэд боловсрол, аюулгүй нэр төртэй ажил эрхлэх боломж бий болгох болтугай. (Номлогч. 7:12)

23. Эзэн минь, Тимор-Лестед олон нийтийн удирдагчдыг чиглүүлж, бүх хүүхдэд сургалтын боломж, багш, ном, аюулгүй сургууль хангаж, ирээдүй нь цэцэглэн хөгжих болтугай. (Иаков 1:5)

24. Эзэн минь, Уругвайд эмэгтэйчүүдэд шударга ажил эрхлэлтийн боломж, ажлын байран дахь хүндлэл, сайн чанартай ажлын байр - ялангуяа хөдөө, бага орлоготой бүсэд - олдоосой. (Кол. 3:23-24)

25. Эзэн минь, АНУ-ын бага орлоготой сургуулийн дүүргүүдийн залуу эмэгтэйчүүд чанартай боловсрол авахад хэрэгтэй нөөц ба өөрчлөлтийг авчраач. (1 Иох. 3:17-18)

26. Эзэн минь, Вьетнамын хамгаалалтгүй нөхцөлд хөдөлмөрлөдөг албан бус ажилчдад өршөөл үзүүлж,

тэднийг хүчирхэгжүүлэн, илүү аюулгүй боломж олгож, удирдагчдыг гэр бүл бүрт шударга, аюулгүй ажил бий болгоход чиглүүлээч. (Дуу. 140:12)

27. Эзэн минь, шударга ёс ба мэргэн ухаан Танд бий. Арабын ертөнцийн засгийн газрууд нөөцөө зөв удирдаж, эмзэг гэр бүлүүдийг хамгаалж, эмэгтэйчүүд цэцэглэн хөгжих боломжийг бий болгох болтугай. (Иаков 1:22)

28. Эзэн минь, Камбожид банк эсвэл хувийн зээлдүүлэгчдийн өндөр хүүгийн өрөнд баригдсан хүмүүст жинхэнэ шийдэл, эрх чөлөө нээж өгөөч. (Сур. 22:7)

29. Эзэн минь, Эсватини улсын бүх охид боловсрол эзэмших боломжтой болох болтугай. Энэрэнгүй зөвлөгч, багш нарыг босгож, тэднийг сургаж чиглүүлэхэд ашиглаач. (Фил. 4:9)

30. Эзэн минь, Монголд ганц бие ээжүүд, хөдөөний ажилчид инфляц ба амьжиргааны өртөг өсөлтөөс болж тэмцэж байна. Тэдэнд нэр төртэй, шударга, тогтвортой орлого өгөх ажлын боломж олгуулж өгөөч. (Дэд хууль. 28:12)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Гэр бүл, хүүхдийн хамгаалал, хүчирхийлэл буурах: Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрал багасч, хохирогчид аюулгүй хамгаалалт, эдгэрэл авахын төлөө. (Дуу. 147:3)

2. Залуусын сэтгэцийн эрүүл мэнд, донтолтоос чөлөөлөгдөх: Сэтгэл гутрал, түгшүүр, амиа хорлолтын бодол, архи/мансууруулах бодис, цахим/мөрийтэй тоглоомын донт олтоос аврагдаж, зөв дэмжлэг, зөвлөх үйлчилгээ хүрэхийн төлөө. (Иса. 41:10)

3. Ажил эрхлэлт, амьжиргааны дарамт, өрийн асуудал: Инфляц, үнэ өсөлт, өр, орлогын тогтворгүй байдлаас болж стресстэж буй өрхүүдэд Бурханы хангалт, зохистой ажил, шударга боломж нээгдэхийн төлөө. (Фил. 4:19)

4. Боловсролын чанар, тэгш хүртээмж: Хөдөө орон нутаг, хотын ялгаа багасч, багш нарын ачаалал буурч, хүүхдүүд чанартай боловсрол, аюулгүй орчин, зөв хүмүүжил авахын төлөө. (Сур. 4:13)

5. Авлига, шударга ёс, ёс суртахуунтай удирдлага: Авлига буурч, шударга ёс тогтож, шүүх/төрийн байгууллагууд үнэн зөв ажиллаж, удирдагчид мэргэн ухаан ба энэрлээр ард иргэддээ үйлчлэхийн төлөө. (Мих. 6:8)

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.